



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 41

Чингис хот

Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 65 дугаар тогтоолоор туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Баярсайхан овогтой Баярмагнайг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Хүн ам нийгмийн бодлогын мэргэжилтний сул ажлын байранд санал болгосугай.

2. Энэхүү тогтоолыг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга /З.Ууганжаргал/-д хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР